



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-ҮҮР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/16

Цагаан-Үүр сум

**Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх
арга хэмжээг хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухайн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэхь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуурайшилтын улирал эхэлж байгаатай холбогдуулан 2024 оны 3 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 10, 9 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах, ногоон бүсэд нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахыг хориглосугай.

2.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг идэвхжүүлэх, шуурхай илрүүлэх, унтраах арга хэмжээг удирдан чиглүүлэх, алслагдсан бүс нутагт айл өрх, малчдыг татан оролцуулах, холбогдох газруудад мэдээ мэдээлэл дамжуулах үүрэг бүхий хариуцлагатай эргүүл жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Идэвхтэн байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг харгалзан шуудан холбоо, уналгын хөлс, үр дүнгийн урамшууллыг тухай бүр тооцож, өдөр тутмын шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (С.Үүрийнбаяр)-д үүрэг болгосугай.

4.Гамшиг осол, объектын болон ой хээрийн түймрийн үед ашиглах зориулалттай газар орны нэршил, айл өрх, хүн ам, мал, амьтны тоог багтаасан ажлын төлөвлөлт хийж 2024 оны 4 дүгээр сарын 01-ний дотор боловсруулан баталгаажуулж, гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд шуурхай хүргэж, дайчилгаа зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга, байгаль хамгаалагч нарт даалгасугай.

5. Суманд гарч болзошгүй гамшиг ослын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж Хилийн застав, Хил хамгаалах туслах хүчний гишүүд, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч, Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч, ойн анги, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагааны хамтын уялдаа холбоог хангаж гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөн сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж ажиллахыг

My com\D\захирамж\

6704301055

Засаг даргын орлогч Байгаль орчин тогтвортой хөгжлийн тасгийн дарга (Ш.Пүрэвдаваа)-д үүрэг болгосугай.

6. Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, шаардлагатай тохиолдолд ой хээрийн болон объектийн гал түймэр, гамшиг ослын голомтод дайчлагдан ажиллах ажилтан, албан хаагчдын бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, хоол хүнс, багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлж гамшгийн үеийн зарлан мэдээллийн дохио дамжуулсан үед сумын Засаг даргын Тамгын газрын өмнөх талбайд цуглахаар үүрэгжүүлж ажиллахыг төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

7. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дарга Засаг даргын Тамгын газрын дарга (С.Үүрийнбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАТМӨНХ